



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

САНХҮҮГИЙН АУДИТЫН ТАЙЛАН

СОЁЛ УРЛАГИЙН ГАЗРЫН 2021 ОНЫ САНХҮҮГИЙН ТАЙЛАН,
ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛД ХИЙСЭН АУДИТЫН ТАЙЛАН

АУДИТЫН КОД: АХГ-2022/192/НА-СТА-ТШЗ

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг
дараах хаягаар авна уу.



Аудитын хоёрдугаар газрын захирал, тэргүүлэх
аудитор Ц.Наранчимэг
Утас: 261663 Цахим хаяг: naranchimegts@audit.gov.mn
Аудитын менежер: С.Нацагдорж
Утас: 261628 Цахим хаяг: natsagdorjs@audit.gov.mn
Аудитор: П.Амарсанаа
Утас: 261740 Цахим хаяг: amarsanaap@audit.gov.mn
Аудитыг гэрээгээр гүйцэтгэсэн: "Шинэ их тэрбум аудит" ХХК
Захирал: Ц.Мишигдорж
Цахим хаяг: ikhterbum@gmail.com

Улаанбаатар хот
2022 он

Агуулга

1. Аудитын санал дүгнэлт	3
2. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлан	5
3. Аудитын тайлан	14
3.1 Ерөнхий зүйл	14
3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт	14
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал	15
3.4 Материаллаг байдал	15
3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга	16
3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв	17
3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг	18
3.8 Аудитын гол асуудал	19
3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал	19
3.10 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт	20
3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал	21
4. Аудитын илрүүлэлт	22

Товчилсон үгийн жагсаалт

АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
АХГ	Аудитын хоёрдугаар газар
НА	Нотлох ажил
СТА	Санхүүгийн тайлангийн аудит
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар
ТЗУГ	Төрийн захиргаа, удирдлагын газар
ТШЗ	Төсвийн шууд захирагч
УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
ҮАГ	Үндэсний аудитын газар
ХШУДАГ	Хяналт шинжилгээ үнэлгээ дотоод аудитын газар



СОЁЛ УРЛАГИЙН ГАЗРЫН ДАРГА
Ц.НАЦАГДОЛГОР ТАНАА

ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг
Бага тойруу-3, Засгийн газрын IV байр
Утас:26-04-37, Факс:51-26-42-30
E-mail: info@audit.gov.mn

2022-02-25 № 07/435
танай _____-ны № _____-т

Аудитын санал дүгнэлт

Хязгаарлалттай дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Соёл урлагийн газрын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Дүгнэлтийн үндэслэл хэсэгт дурдсан алдаа, зөрчлийн үр нөлөөг эс тооцвол Соёл урлагийн газрын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторовын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч байгууллагаас хараат бус, аудиторовын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний байгууллагаас цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар нийт 351,257.8 мянган төгрөгийн алдаа зөрчил илэрч тогтоосон ерөнхий материаллаг байдлын түвшнээс давсан нь дангаараа буюу эсвэл нийтээрээ санхүүгийн тайланд материаллаг боловч өргөн тархаагүй, Төсвийн тухай хуулийн 5.1.3, 6.4.1, 6.4.8, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйл 13.5, Захиргааны Ерөнхий хуулийн 103 дугаар зүйлийн 103.2, нийцсэн бөгөөд зохистой байх, тохиолдсон байх, ангилал, толилуулга зэрэг батламж мэдэгдлүүдийг хангахгүй байна.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар материаллаг буруу илэрхийлэл бүгдийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

АУДИТЫН ХОЁРДУГААР ГАЗРЫН
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ц.НАРАНЧИМЭГ

2. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлан

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	13,688,903.33	752,304,409.00
33	АВЛАГА	8,913,254.33	743,643,000.00
33300	Татаас, санхүүжилтийн авлага	-	743,643,000.00
335	Бусад авлага	8,913,254.33	-
3351	Байгууллагаас авах авлага	8,913,254.33	-
35	БАРАА МАТЕРИАЛ	4,775,649.00	8,661,409.00
354	Хангамжийн материал	4,775,649.00	8,661,409.00
35410	Бичиг хэргийн материал	00.00	1,797,260.00
35420	Аж ахуйн материал	2,720,949.00	4,809,449.00
35470	Бусад хангамжийн материал	2,054,700.00	2,054,700.00
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	70,346,902.40	56,807,390.72
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	70,346,902.40	56,807,390.72
392	Биет хөрөнгө	70,243,777.50	56,773,015.86
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	91,539,882.28	93,194,282.28
39206	Хуримтлагдсан элэгдэл	(43,198,399.78)	(56,525,403.78)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	44,968,428.74	46,027,728.74
39208	Хуримтлагдсан элэгдэл	(23,066,133.74)	(25,923,591.38)
393	Биет бус хөрөнгө	103,124.90	34,374.86
39301	Програм хангамж	1,155,000.00	1,155,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	(1,051,875.10)	(1,120,625.14)
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	84,035,805.73	809,111,799.72
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	2,344,612.47	1,933,852.47
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	2,344,612.47	1,933,852.47
413	Өглөг	2,344,612.47	1,933,852.47
4136	Бусад өглөг	2,344,612.47	1,933,852.47
41361	Байгууллагад төлөх өглөг	2,344,612.47	1,933,852.47
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	81,691,193.26	114,534,947.25
51	Засгийн газрын хувь оролцоо	81,691,193.26	114,534,947.25
512	Хуримтлагдсан үр дүн	81,691,193.26	114,534,947.25
51210	Өмнөх үеийн үр дүн	81,691,193.26	81,691,193.26
51220	Тайлант үеийн үр дүн	-	725,486,753.99
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	84,035,805.73	809,111,799.72

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	917,638,594.33	2,399,101,900.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	68,537,094.33	2,214,400.00
120	Нийтлэг татварын бус орлого	68,537,094.33	2,214,400.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	68,537,094.33	2,214,400.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	12,143,394.33	560,000.00
120017	Үнэ төлбөргүй хүлээн авсан үндсэн хөрөнгө	56,393,700.00	1,654,400.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	849,101,500.00	2,396,887,500.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	831,801,500.00	565,653,600.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	831,801,500.00	565,653,600.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	17,300,000.00	1,831,233,900.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	17,300,000.00	1,831,233,900.00
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	861,167,509.84	1,673,615,146.01
21	УРСГАЛ ЗАРДАЛ	861,167,509.84	1,673,615,146.01
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	708,137,475.06	1,527,143,947.73
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	239,881,472.22	203,252,807.02
210101	Үндсэн цалин	171,680,176.88	192,241,221.30
210102	Нэмэгдэл	68,201,295.34	11,011,585.72
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	28,633,604.00	26,828,819.94
210201	Тэтгэврийн даатгал	19,299,404.00	18,559,908.72
210202	Тэтгэмжийн даатгал	2,435,000.00	2,105,299.13
210203	ҮОМШӨ-ний даатгал	1,948,000.00	1,644,238.01
210204	Ажилгүйдлийн даатгал	487,000.00	408,776.86
210205	Эрүүл мэндийн даатгал	4,464,200.00	4,110,597.22
2104	Хангамж, бараа материалын зардал	27,414,867.47	36,999,229.09
210401	Бичиг хэрэг	4,165,800.00	13,698,600.00
210402	Тээвэр, шатахуун	12,033,652.47	14,072,000.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	8,390,814.00	7,744,569.09
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	2,824,601.00	1,484,060.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	11,911,903.00	39,000.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	4,918,799.00	39,000.00
210604	Урсгал засвар	6,993,104.00	
2107	Томилолт, зочны зардал	715,600.00	676,000.00
210702	Дотоод албан томилолт	715,600.00	676,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	325,972,980.00	1,203,718,880.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	318,972,980.00	1,196,718,880.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	7,000,000.00	7,000,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	73,607,048.37	55,629,211.68
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	62,868,130.00	39,376,000.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	10,738,918.37	16,253,211.68
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	153,030,034.78	146,471,198.28
2132	Бусад урсгал шилжүүлэг	30,000,000.00	6,567,500.00
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	30,000,000.00	-

213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	-	6,567,500.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	123,030,034.78	97,163,058.28
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	114,193,614.78	97,163,058.28
213305	Төвлөрүүлэх шилжүүлэг-Нэмэлт санхүүжилт	8,836,420.00	
2135	Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг	-	42,740,640.00
213503	Төвлөрүүлэх шилжүүлэг	-	42,740,640.00
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	56,471,084.49	725,486,753.99
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	56,471,084.49	725,486,753.99

2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
C01	2019 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	-	-	25,220,108.77	25,220,108.77
C02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-	-	-	-
C03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	-	-	25,220,108.77	25,220,108.77
C07	Тайлант үеийн үр дүн	-	-	56,471,084.49	56,471,084.49
C08	2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	-	-	81,691,193.26	81,691,193.26
D02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-	-	-	-
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	-	-	81,691,193.26	81,691,193.26
D08	Тайлант үеийн үр дүн	-	-	725,486,753.99	725,486,753.99
D09	2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	-	-	807,177,947.25	807,177,947.25

2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	849,101,640.00	2,406,283,920.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	-	560,000.00
120	Нийтлэг татварын бус орлого	-	560,000.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	-	560,000.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	-	560,000.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	849,101,640.00	2,405,723,920.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	831,801,500.00	565,653,600.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	831,801,500.00	565,653,600.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	17,300,000.00	1,840,070,320.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	17,300,000.00	1,831,233,900.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	-	8,836,420.00
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	849,101,500.00	1,661,581,620.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	849,101,500.00	1,661,581,620.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	699,301,605.22	1,515,110,421.72
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	238,498,438.22	202,041,278.87
210101	Үндсэн цалин	170,297,142.88	151,668,749.94
210102	Нэмэгдэл	68,201,295.34	50,372,528.93
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	30,016,638.00	27,963,513.76
210201	Тэтгэврийн даатгал	20,276,638.00	19,190,428.34
210202	Тэтгэмжийн даатгал	2,435,000.00	2,215,890.63
210203	ҮОМШӨ-ний даатгал	1,948,000.00	1,749,115.39
210204	Ажилгүйдлийн даатгал	487,000.00	435,096.16
210205	Эрүүл мэндийн даатгал	4,870,000.00	4,372,983.24
2104	Хангамж, бараа материалын зардал	25,387,955.00	23,738,189.09
210401	Бичиг хэрэг	4,165,800.00	3,610,600.00
210402	Тээвэр, шатахуун	10,099,800.00	11,397,400.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	8,297,754.00	7,837,629.09
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	2,824,601.00	892,560.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	12,952,604.00	978,400.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	5,959,500.00	978,400.00
210604	Урсгал засвар	6,993,104.00	
2107	Томилолт, зочны зардал	715,600.00	676,000.00
210702	Дотоод албан томилолт	715,600.00	676,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	327,738,260.00	1,216,686,880.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	320,738,260.00	1,209,686,880.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	7,000,000.00	7,000,000.00

2109	Бараа үйлчилгээний бусад зардал	63,992,110.00	43,026,160.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	63,992,110.00	43,026,160.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	149,799,894.78	146,471,198.28
2132	Бусад урсгал шилжүүлэг	30,000,000.00	6,567,500.00
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	30,000,000.00	-
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	-	6,567,500.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	123,030,034.78	97,163,058.28
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	110,963,474.78	97,163,058.28
213305	Төвлөрүүлэх шилжүүлэг-Нэмэлт санхүүжилт	8,836,420.00	-
2135	Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг	-	786,383,640.00
213503	Төвлөрүүлэх шилжүүлэг-Нэмэлт санхүүжилт	-	786,383,640.00
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	-	1,059,300.00
5	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)	-	-
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	-	1,059,300.00
2200	Дотоод эх үүсвэрээр	-	1,059,300.00
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	-	1,059,300.00
6	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)	-	(1,059,300.00)
7	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	-	-
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)	-	-
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	-
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	-

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Код	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	714,508,700.00	468,490,541.72	246,018,158.28
21	УРСГАЛ ЗАРДАЛ	714,508,700.00	468,490,541.72	246,018,158.28
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	690,098,700.00	468,080,541.72	222,018,158.28
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	243,500,000.00	202,041,278.87	41,458,721.13
210101	Үндсэн цалин	173,177,100.00	151,668,749.94	21,508,350.06
210102	Нэмэгдэл	70,322,900.00	50,372,528.93	19,950,371.07
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	32,872,500.00	27,963,513.76	4,908,986.24
210201	Тэтгэврийн даатгал	23,132,500.00	19,190,428.34	3,942,071.66
210202	Тэтгэмжийн даатгал	2,435,000.00	2,215,890.63	219,109.37
210203	ҮОМШӨ-ний даатгал	1,948,000.00	1,749,115.39	198,884.61
210204	Ажилгүйдлийн даатгал	487,000.00	435,096.16	51,903.84
210205	Эрүүл мэндийн даатгал	4,870,000.00	4,372,983.24	497,016.76
2104	Хангамж, бараа материалын зардал	23,755,600.00	23,738,189.09	17,410.91
210401	Бичиг хэрэг	5,368,700.00	3,610,600.00	1,758,100.00
210402	Тээвэр, шатахуун	7,778,300.00	11,397,400.00	(3,619,100.00)
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	7,815,600.00	7,837,629.09	(22,029.09)
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	2,793,000.00	892,560.00	1,900,440.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	4,209,500.00	2,037,700.00	2,171,800.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	4,209,500.00	2,037,700.00	2,171,800.00
2107	Томилолт, зочны зардал	679,600.00	676,000.00	3,600.00
210702	Дотоод албан томилолт	679,600.00	676,000.00	3,600.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	320,247,000.00	168,597,700.00	151,649,300.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	313,247,000.00	161,597,700.00	151,649,300.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	7,000,000.00	7,000,000.00	-
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	64,834,500.00	43,026,160.00	21,808,340.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	64,834,500.00	43,026,160.00	21,808,340.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	24,410,000.00	410,000.00	24,000,000.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	24,410,000.00	410,000.00	24,000,000.00
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	24,000,000.00	-	24,000,000.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	410,000.00	410,000.00	-
	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	714,508,700.00	468,490,541.72	246,018,158.28
1310	УЛСЫН ТӨСВӨӨС	714,508,700.00	468,490,541.72	246,018,158.28

	САНХҮҮЖИХ			
131001	Улсын төсвөөс санхүүжих	714,508,700.00	468,490,541.72	246,018,158.28
62	АЖИЛЛАГСАДЫН ТОО	17	17	-
620001	Удирдах ажилтан	1	1	-
620002	Гүйцэтгэх ажилтан	14	14	-
620003	Үйлчлэх ажилтан	2	2	-

2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл
НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН		1,840,630,320.00
УРСГАЛ ЗАРДАЛ		1,840,630,320.00
БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ		1,048,089,180.00
Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж		1,048,089,180.00
Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж		1,048,089,180.00
УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ		792,541,140.00
Бусад урсгал шилжүүлэг		6,157,500.00
Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал		6,157,500.00
Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг		786,383,640.00
Төвлөрүүлэх шилжүүлэг		42,740,640.00
ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР		1,840,630,320.00
УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ		137,000,000.00
Улсын төсвөөс санхүүжих		137,000,000.00
ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС		560,000.00
Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих		560,000.00
Нэмэлт санхүүжилтийн орлого		1,703,070,320.00
Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө		1,694,233,900.00
Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого		8,836,420.00
НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(II)-(I)		-

3. Аудитын тайлан

3.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана” гэж заасны дагуу Соёл урлагийн газрын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд шалгагдагч байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудитын санал дүгнэлт, түүний үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Энэхүү тайланд шалгагдагч байгууллагад төсвийн гүйцэтгэлийн тайланг иж бүрэн гаргаж, хөтөлбөр арга хэмжээнд зарцуулсан төсөв, хүрсэн үр дүн, биелэлт, хэрэгжүүлээгүй бол шалтгаан зэрэг нэмэлт мэдээллүүдийг тайлагнаж байх талаар өгсөн зөвлөмжийг тусгасан болно.

Аудитыг 2022 оны 1 дүгээр сарын 15-наас 2 дугаар сарын 18-ны хооронд Шинэ их тэрбум аудит ХХК-ийн ахлах аудитор Т.Меруерт, аудиторын туслах М.Оюунтуяа нар гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер Д.Дашдулам, захирал Ц.Мишигдорж нар тус тус хэрэгжүүлсэн.

Соёл урлагийн газар 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг Шинэ их тэрбум аудит ХХК-д 2022 оны 1 дүгээр сарын 20-ны өдрийн 8 тоот албан бичгээр ирүүлсэн байна.

3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт

Соёл урлагийн газрын эрхэм зорилго нь төрөөс соёл урлагийн салбарын хөгжлийн бодлого боловсруулахад дэмжлэг үзүүлэх, тус салбарт явуулж буй төрийн бодлогыг хэрэгжүүлэх замаар соёл урлагийн салбарын нийгэм эдийн засгийн хөгжилд гүйцэтгэх үүргийг нэмэгдүүлэхэд оршино.

Соёл урлагийн газрын үйл ажиллагааны чиглэлийг дараах байдлаар тодорхойлжээ. Үүнд:

- Хувь хүний хөгжил, нийтийн соёлыг дэмжсэн, өрсөлдөөнд суурилсан соёл, урлагийн хүртээмжтэй, олон талт үйлчилгээг нийгэмд хүргэж чадахуйц өрсөлдөх чадвар бүхий тогтвортой, хариуцлагатай, үр ашигтай үндэсний үйлчилгээний тогтолцоо, соёлын үйлдвэрлэлийг хөгжүүлэх, бэхжүүлэх;
- Соёлын өвийн бүртгэл, хяналт, мэдээллийн нэгдсэн тогтолцоо, соёлын өвийг хамгаалах, сэргээн засварлах, баяжуулах, өвлүүлэх найдвартай тогтолцоог бэхжүүлэх;
- Соёл урлагийн салбарын тоо, бүртгэл мэдээллийг боловсронгуй болгох, нэгдсэн системд оруулж үйл ажиллагааг тогтворжуулах;
- Соёлын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад салбарын хөгжлийн бодлого боловсруулахад дэмжлэг үзүүлэх, шаардлагатай мэдээллээр хангах;
- Нээлттэй, ил тод, шуурхай, чанартай, хүртээмжтэй ажил, үйлчилгээ үзүүлэх.

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд дараах өөрчлөлт орсон байна. Үүнд:

- Соёлын тухай хууль 2021 оны 7 дугаар сарын 02-ны өдөр батлагдсан, 2022 оны 1 дүгээр сарын 1-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөх;
- Музейн тухай хууль 2021 оны 1 дүгээр сарын 29-ний өдөр батлагдаж, 2022 оны 1 дүгээр сарын 1-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөх;
- Сангийн сайдын 2021 оны 190 дүгээр тушаал “Зардлын эдийн засгийн ангилал ашиглах заавар”
- Засгийн газрын 2021 оны 43 дугаар тогтоол “Төсвийн хэмнэлтийн талаар авах зарим арга хэмжээний тухай”

- Засгийн газрын 2021 оны 124 дүгээр тогтоол “Босго үнэ шинэчлэн батлах тухай”

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөгүй байна.

Захиргааны хэлтсийн Хяналт-шинжилгээ, үнэлгээ, хууль тогтоомжийн биелэлт, дотоод хяналт хариуцсан ахлах мэргэжилтэнтэй боловч дотоод хяналтын ажлыг хэрэгжүүлээгүй, үр дүнгийн ажлын тайланг гаргаж ирүүлээгүй.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

Соёлын яамны ХШҮДАГ-аас 2020-2021 оны эхний хагас жилийн үйл ажиллагаа, газрын дарга болон холбогдох албан тушаалтны хуулиар хүлээсэн чиг үүргийн хэрэгжилтэд дотоод хяналт шалгалт явуулж, “Хангалтгүй” гэсэн дүгнэлт өгч, зөвлөмжийг хүргүүлсэн байна.

Соёл урлагийн газар нь Соёлын яамны ХШҮДАГ-аас хэрэгжүүлсэн шалгалтын тайланг хүлээн зөвшөөрөөгүй, зөвлөмжийн биелэлтийг хангаагүй байна.

Бид дотоод аудитын тайланг 2022 оны 2 дугаар сарын 17-ны өдөр Соёлын яамнаас хүлээн авч танилцсан тул дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглаагүй, дотоод аудитаар илэрсэн гол зөрчлүүдийг энэ тайлангийн асуудлыг онцолсон хэсэгт тусгасан.

Яамны дотоод аудитын тайлан, зөвлөмжийг аудитад шаардлагатай баримтын жагсаалтад оруулж, аудитад танилцуулахыг шаадсан боловч гаргаж өгөөгүй. Хяналт шинжилгээ үнэлгээ, дотоод аудитын тайлан, Соёл урлагийн газрын 2021 оны төсөвт оруулсан өөрчлөлтийн талаар мэдээлэл хүсэж Соёлын яамны ТЗУГ-т 2022 оны 1 дүгээр сарын 24-нд захидал илгээсэн. Соёлын яамны ХШҮДАГ-аас 2022 оны 2 дугаар сарын 16-нд 10/339 тоотоор тайланг ирүүлсэн. Бид энэ үед аудитын асуудлын бүртгэлийг гарган ҮАГ-т хүргүүлсэн.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Соёл урлагийн газрын 2021 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккрузал сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн хүлээн зөвшөөрөхүйц санхүүгийн тайлагналын үзэл баримтлал гэж үнэлсэн.

Төсвийн гүйцэтгэлийн тайланг төсвийн тухай хуулийн 54.5-д заасан бүрэлдэхүүн хэсгийн дагуу иж бүрэн бэлтгээгүй байна.

3.4 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл “өндөр” гэж үнэлэн материаллаг байдлын түвшинг 0.5 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2020 оны үр дүнгийн тайлангийн нийт зардлын 861,167.5 мянган төгрөгөөс 0.5 хувиар буюу 4,305.8 мянган төгрөгөөр тогтоосон.

Тогтоосон төлөвлөлтийн ерөнхий материаллаг байдлыг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагатай гэж үзсэн.

Гүйцэтгэлийн үе шатанд материаллаг байдлыг 2021 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлын 2,366,258.1 мянган төгрөгөөс 0.5 хувиар буюу 11,831.3 мянган төгрөгөөр шинэчлэн тогтоолоо.

2021 оны жилийн эцсийн санхүүгийн тайлангийн суурь үзүүлэлт нь Ардын хувьсгалын 100 жилийн ой, Үндэсний хөтөлбөртэй холбоотойгоор нэмэлт санхүүжилт материаллаг зөрүүтэй өссөн тул шинэчлэн тогтоох шаардлагатай гэж үзсэн.

3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга

Соёл урлагийн газрын 2021 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 725,076.0 мянган төгрөгөөр буюу 862.8 хувиар өссөн байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан авлага, үндсэн хөрөнгө, хуримтлагдсан үр дүнгийн данс байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/мянган төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Авлага	8,913.3	743,643.0	734,729.7
Бараа материал	4,775.6	8,661.4	3,885.8
Үндсэн хөрөнгө	70,346.9	56,807.4	(13,539.5)
Нийт хөрөнгө	84,035.8	809,111.8	725,076.0
Өр төлбөр	2,344.6	1,933.9	(410.7)
Хуримтлагдсан үр дүн	81,691.2	807,177.9	725,486.7
Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн	84,035.8	809,111.8	725,076.0

Авлага дансны үлдэгдэл 743,643.0 мянган төгрөг болж, 734,729.7 мянган төгрөгөөр өссөн нь хэрэгжүүлсэн төсөл арга хэмжээнээс үүссэн үлдэгдэл төлбөрийн татаас санхүүжилтийн авлагатай холбоотой.

Бараа материалын дансны үлдэгдэл 8,661.4 мянган төгрөг болж, 3,885.8 мянган төгрөгөөр өссөн нь бичиг хэрэг, аж ахуйн материал шинээр худалдаж авснаас шалтгаалжээ. Тайлант онд 18,753.4 мянган төгрөгийн хангамжийн материал худалдан авч, 14,867.7 мянган төгрөгийн материал зарцуулж, 8,661.4 мянган төгрөгийн үлдэгдэлтэй байна.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 56,807.4 мянган төгрөг болж, 13,539.5 мянган төгрөгөөр буурсан нь тайлант оны элэгдлийн зардлаас шалтгаалжээ. Үндсэн хөрөнгийн данс нь урсгал төсвийн худалдан авалтаар 1,059.3 мянган төгрөг, хандиваар болон үнэ төлбөргүй шилжиж ирсэн 1,654.4 мянган төгрөгөөр нэмэгдсэн байна.

Биет бус хөрөнгө нь тайлант онд 68.8 мянган төгрөгөөр хорогдлын зардлаар буурсан байна.

Өр төлбөр дансны үлдэгдэл 1,933.9 мянган төгрөг болж, 410.7 мянган төгрөгөөр буурсан нь бэлтгэн нийлүүлэгч байгууллагад өр төлбөрийг барагдуулснаас шалтгаалжээ.

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 807,177.9 мянган төгрөг болж, 725,076.0 мянган төгрөгөөр өссөн нь тайлант оны үйл ажиллагааны үр дүнгээс шалтгаалсан байна.

Соёл урлагийн газрын санхүүгийн үр дүнгийн тайлангаар нийт орлого өмнөх оноос 1,481,463.3 мянган төгрөгөөр буюу 161.4 хувиар өссөн байна.

Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан нь урсгал үйл ажиллагааны санхүүжилтийн орлого 266,147.9 мянган төгрөгөөр буурсан, нэмэлт санхүүжилтийн орлого 1,813,933.9 мянган төгрөгөөр өссөн нь Ардын хувьсгалын 100 жилийн ой, соёл урлагийг хөгжүүлэх Үндэсний хөтөлбөртэй холбоотойгоор өссөн байна.

Нийт зардал өмнөх оноос 1,505,090.6 мянган төгрөгөөр буюу 174.8 хувиар өссөн байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан бусдаар гүйцэтгүүлсэн төсөл арга хэмжээний зардлууд байна. Энэ нь Ардын хувьсгалын 100 жилийн ой, Үндэсний төсөл хөтөлбөрт нэмэлт санхүүжилт олгосноос төсөл, арга хэмжээний зардлууд өссөнтэй холбоотой байна.

3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.6.1 Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2021 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг 796,851.4 мянган төгрөгөөр, нийт зарлагыг 796,851.4 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төсвийн захирагчийн хүргүүлсэн төсвийн төслөөс 82,342.7 мянган төгрөгөөр бууруулж 714,508.7 мянган төгрөгөөр баталсан байна.

3.6.2 Төсвийн гүйцэтгэл

Тайлант онд төсвийн шууд захирагчийн хэрэгжүүлэх 11 хөтөлбөрийн 19 арга хэмжээг санхүүжүүлэхээр 714,508.7 мянган төгрөгийн төсөв баталснаас 714,508.7 мянган төгрөгийг улсын төсвөөс санхүүжүүлэхээр төлөвлөжээ.

Гүйцэтгэлээр улсын төсвөөс 565,653.6 мянган төгрөгийн санхүүжилт авч, бараа, ажил үйлчилгээний зардалд 468,080.5 мянган төгрөг, бусад урсгал шилжүүлгэд 410.0 мянган төгрөгийг тус тус зарцуулж, 97,163.1 мянган төгрөгийг улсын төсөвт буцаан төвлөрүүлсэн байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 468,490.5 мянган төгрөг буюу 82.8 хувьтай байгаа нь цалингийн зардлыг 46,367.7 мянган төгрөгөөр, бараа үйлчилгээний бусад зардлыг 4,841.8 мянган төгрөгөөр, сургалтын зардлыг 9,471.0 мянган төгрөгөөр, төсөл арга хэмжээний зардлыг 36,482.6 мянган төгрөгөөр тус тус дутуу зарцуулсантай холбоотой байна.

Хүснэгт-2 Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл

/мянган төгрөг/

Д/д	Хөтөлбөр, арга хэмжээний		Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Биелэлт
	Код	Нэр				
1	71702	Соёл урлаг	565,653.6	468,490.5	97,163.1	82.8%
Нийт дүн			565,653.6	468,490.5	97,163.1	82.8%

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

3.6.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Дээд шатны төсвийн захирагчаас 1,694,233.9 мянган төгрөг, үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого 8,836.4 мянга, улсын төсвөөс 137,000.0 мянга, туслах үйл ажиллагааны орлогоос 560.0 мянга, нийт 1,840,630.3 мянган төгрөгийн орлогыг бүрдүүлжээ.

Үүнээс бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамжинд 1,048,089.2 мянга, нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулалд 6,157.5 мянга, нийт 1,054,246.7 мянган төгрөгийг зарцуулж, үлдэгдэл 786,383.6 мянган төгрөгийг улсын төсөвт төвлөрүүлжээ.

Нэмэлт төсвийн зардлын гүйцэтгэлийг дутуу зарцуулсан нь Ардын хувьсгалын 100 жилийн ойг зохион байгуулах ажлын хүрээнд хэрэгжүүлэх 9 төсөл, хөтөлбөр, арга хэмжээнээс КОВИД-19 цар тахалтай холбоотойгоор зарим хөтөлбөр арга хэмжээ хэрэгжээгүй, цахимаар хэрэгжүүлэх боломжтой 4 хөтөлбөр арга хэмжээнд 777,342.8 мянган төгрөг зарцуулсан, Үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх ажлын хүрээнд төлөвлөгдсөн хөтөлбөр арга хэмжээнд 264,500.0 төгрөг зарцуулсантай холбоотой байна.

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг

Соёл урлагийн газар нь үндсэн 17 ажилтантай, захиргаа удирдлагын, соёлын өвийн, урлаг уран бүтээлийн гэсэн 3 албанаас бүрддэг.

Тайлант онд төслийн хэрэгжүүлэх хөтөлбөр, хөтөлбөрийн хүрэх үр дүнгийн талаарх чанарын болон тоо хэмжээний үзүүлэлтэд тусгагдсан хөтөлбөр, арга хэмжээнд зориулан төлөвлөж, зарцуулсан төсвийн гүйцэтгэл 82.8 хувийн биелэлттэй байна.

Ардын хувьсгалын 100 жилийн ойн арга хэмжээ зохион байгуулах ажлын хүрээнд тусгагдсан 9 төсөл, арга хэмжээний хэрэгжилт 38.7 хувь, Үндэсний хөтөлбөрийн хэрэгжилтийг хангах баримтат өвийг хамгаалах, соёлын биет бус өвийг хамгаалах, Чулуун соёлын өв үндсэн хөтөлбөр арга хэмжээний хэрэгжилт 58.1 хувийн биелэлттэй, хөтөлбөр арга хэмжээнд зориулан төлөвлөж зарцуулсан төсвийн гүйцэтгэл 57.3 хувийн биелэлттэй байна.

Соёлын яамны ХШҮДАГ-аас шалгагдагч байгууллагын 2020-2021 оны эхний хагас жилийн үйл ажиллагаа, газрын дарга болон холбогдох албан тушаалтны хуулиар хүлээсэн чиг үүргийн хэрэгжилтэд хийсэн хяналт шалгалтаар дараах анхаарал татахуйц зөрчлүүд гарсан байна. Үүнд:

- Байгууллагын дотоод хяналтын үйл явцын төлөвшил бүрдээгүй, дотоод хяналт, эрсдэлийн удирдлагын чиглэлээр мэргэшсэн албан хаагчийг батлагдсан орон тоонд томилоогүй, тухайн жилд хийх ажлын төлөвлөгөөг баталж, хэрэгжүүлээгүй, төсөв санхүүгийн үйл ажиллагаанд тавих дотоод хяналт хэрэгжээгүй;
- Худалдан авах ажиллагаатай холбоотойгоор иргэн, хуулийн этгээдтэй байгуулсан гэрээнд тавих хяналт сул, гэрээ дүгнэсэн актыг хуурамчаар үйлдсэн, гэрээний хэрэгжилтийн тайланг гүйцэтгэгч талаас аваагүй, Соёлын яамны ХШҮДАГ-ын хяналт шалгалтаар илрүүлсэн байгууллагын хөрөнгө мөнгийг завшсан байж болзошгүй асуудлуудын хүрээнд Төрийн аудитын тухай хууль болон Төрийн албаны тухай хуульд заасан үндэслэл журмын дагуу холбогдох албан тушаалтанд ёс зүйн болон эрүүгийн хариуцлага хүлээлгэх үндэслэл бүрдсэн байна.

3.8 Аудитын гол асуудал

Соёл урлагийн газрын санхүүгийн тайлангийн аудитад нөлөөлөх гол асуудал байхгүй байна.

3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайлангийн аудитын санал дүгнэлтээс тусад нь салгах ёстой гэж заасан байна.

3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Аудитаар тус хуулийн 6 дугаар зүйлд заасан мэдээллийн давхардал, ач холбогдол, үр нөлөөг харгалзан 22 төрлийн мэдээллийг Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст ил тод байршуулсан эсэхийг хамруулан шалгалаа.

Тайлант хугацаанд оруулбал зохих 175 мэдээллээс хугацаандаа оруулсан 148 мэдээлэл, хугацаа болоогүй 1 мэдээлэл, 2,067,132.4 мянган төгрөгийн 22 мэдээллийг хугацаа хоцроосон; 4 мэдээллийг шилэн дансны цахим хуудсанд байршуулаагүй, шилэн дансны мэдээллийн үнэн зөв, бодитой, иж бүрэн байх зарчмыг хангаж ажиллаагүй.

Шилэн дансны цахим хуудсанд 4,385,309.6 мянган төгрөгийн мэдээлэл байршуулахаас батлагдсан төсөв, төсвийн гүйцэтгэл, хэтрэлт хэмнэлтийн тайлан, төсөвт орсон нэмэлт өөрчлөлтийн мэдээлэл, өмнөх оны аудитын зөвлөмжийн хэрэгжилтийн тайланг байршуулаагүй, 52,913.9 мянган төгрөгийн өр авлага үүсгэсэн тухай шийдвэрийг мэдээлээгүй, Худалдан авах ажиллагаатай холбоотой 144,900.0 мянган төгрөгийн мэдээлэл дутуу байршуулсан, тушаал шийдвэр, тайлан, бусад материалыг хавсаргаж мэдээлээгүй, давтан зөрчил гаргасан нь Шилэн дансны тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1. “Энэ хуулийг хэрэгжүүлэхэд дараах зарчмыг баримтална: 4.1.1.мэдээлэл үнэн зөв, бодитой, иж бүрэн байх, 4.1.3. тогтоосон хугацаанд, тогтмол, шуурхай мэдээлдэг байх;”, Төрийн аудитын тухай хуулийн 42 дугаар зүйлийн 42.1.”Энэ хуулийн 16 дугаар зүйлд заасан этгээд, хүчин төгөлдөр болсон албан шаардлага, төлбөрийн актыг хугацаанд нь биелүүлээгүй, аудитын үйл ажиллагаанд саад учруулсан, санхүүгийн тайлангийн аудитаар сөрөг дүгнэлт авсан, хуулиар хориглосон үйл ажиллагаа явуулсан, албан үүргээ биелүүлээгүй, албан тушаалын бүрэн эрхээ хэтрүүлсэн нь аудитаар илэрсэн бол тухайн албан хаагчид сахилгын шийтгэл ногдуулах үндэслэл болно.” гэсэн заалттай нийцэхгүй, нийцсэн бөгөөд зохистой, иж бүрэн байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь:Хариуцлага тооцуулах албан шаардлага хүргүүлэх;

3.9.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Худалдан авах ажиллагаатай холбоотой дараах зөрчлүүд илэрсэн. Үүнд:

Ардын хувьсгалын 100 жилийн ойг тохиолдуулан 100,000.0 мянган төгрөгийн төсөвтэй "Тусгаар тогтнол шүлгээр дуу бүтээх" ажлын багийг шалгаруулах ажлын хэсгийг А/13 тоот тушаалын дагуу баталж, байгууллагын цахим сайтад сонгон шалгаруулалтыг зарласан. Ажлын хэсгийн хурлын тэмдэглэлд 3 байгууллагаас үнийн санал, материал ирүүлсэн гэж дурдсан боловч ажлын баримтад зөвхөн "Медиа боловсрол суваг" ХХК-аас ирүүлсэн материалыг хавсаргаж хууль бус сонгон шалгаруулалт хийж, төлбөрийн 60 хувь буюу 60,000.0 мянган төгрөгийг шилжүүлсэн нь "Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа үйлчилгээ худалдан авах тухай" хуулийн 8 дугаар зүйлийн "8.2 Энэ хуулийн 8.1.1-д АХГ-2022/192/НА-СТА-ТШЗ

заасан босго үнээс дээш төсөвт өртөгтэй бараа, ажил, үйлчилгээг худалдан авахад энэ хуульд өөрөөр заагаагүй бол нээлттэй тендер шалгаруулалтын журмыг хэрэглэнэ.", 17 дугаар зүйлийн 17.1 "Нээлттэй тендер шалгаруулалтын урилгыг энэ хуулийн 21 дүгээр зүйлд заасны дагуу зарлан мэдээлж, сонирхогч этгээдийг тендер шалгаруулалтад оролцох тэгш боломжоор хангана." гэсэн заалттай нийцэхгүй, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Албан шаардлага хүргүүлэх;

"Нүүдлийн цирк 21 аймагт" тоглолтын 200,000.0 мянган төгрөгийн ажлын цахим тендер зарлаж, байгууллагын үнэлгээний хорооны бичиг баримтад тендерийн ажлыг 210,000.0 мянган төгрөгөөр үнэлж, гэрээ шууд байгуулах нөхцөлөөр "Улаанбаатар цирк" ХХК-ийн ирүүлсэн 209,990.0 мянган төгрөгийн тендерийн саналыг шалгаруулсан боловч шууд гэрээ байгуулах аргыг хэрэглэх болсон үндэслэлийг гэрээний хувийн хамт Сангийн яаманд хүргүүлээгүй, шалгаруулалтын үр дүнг цахим тендерийн сайтад мэдээлээгүй нь Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа ажил үйлчилгээ худалдан авах тухай" хуулийн 34 дүгээр зүйлийн 34.3. "Энэ хуулийн 34.1-д заасны дагуу гэрээ шууд байгуулсан тохиолдолд захиалагч гэрээний хувийг уг аргыг хэрэглэх болсон үндэслэлийн хамт төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад хүргүүлнэ.", "Худалдан авах ажиллагааны цахим системээр тендер шалгаруулалт зохион байгуулах, холбогдох мэдээллийг зарлан мэдээлэх журам"-ын 3 дугаар зүйлийн "3.2.7-д Үнэлгээний хороо хуулийн 29.1-д заасан мэдэгдэл хүргүүлсэн өдөрт багтаан цахим системд тендер шалгаруулалтын үр дүнг үнэн зөв, бүрэн нийтэлж, шалгарсан тендерт оролцогчийн ирүүлсэн тендерийн нууцлаагүй хэсгийг Сангийн сайдын 2019 оны 6 дугаар сарын 4-ний өдрийн 132 дугаар тушаалаар батлагдсан Тендер шалгаруулалтын материалыг тухайн тендерт оролцогчдод ил болгох журам-ын дагуу ил болгох" гэсэн заалтуудыг мөрдөөгүй, нийцсэн бөгөөд зохистой байх, батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Албан шаардлага хүргүүлэх;

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцээгүй, худалдан авах ажиллагаа нь Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа ажил үйлчилгээ худалдан авах тухай хууль, заавар журамтай нийцээгүй, өмнөх оны төлбөрийн актын хэрэгжилтийг хангаж ажиллаагүй гэж дүгнэлээ.

Нягтлан бодогчийг тогтвор суурьшилтай ажиллуулаагүйгээс зөрчлүүд давтагдан гарсаар байна.

3.10 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Соёл, урлагийн газрын 2021 оны эхний хагас жилийн санхүүгийн тайланд завсрын аудит хийх байсан боловч шалгагдагч байгууллага нь хугацаандаа холбогдох материалыг хүлээлгэж өгөөгүй тул завсрын аудит хийгдээгүй болно.

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн 30,670.5 мянган төгрөгийн зөрчилд 1,913.9 мянган төгрөгийн төлбөрийн акт, шилэн данс, төсөв хооронд зохицуулалт хийсэн 25,036.0 мянган төгрөгийн зөрчлийг арилгах албан шаардлагыг тус тус биелүүлээгүй байна. Аудитаар өгсөн 3,720.6 мянган төгрөгийн зөвлөмжийн хэрэгжилт 50 хувьтай байна.

Хүснэгт 3 Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн төлбөрийн акт, албан шаардлагын хэрэгжилт /мянган төгрөг/

Үзүүлэлт	Өмнөх оны илрүүлэлт		Биелэлт		Зөрүү		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Акт	1	1,913.9	-	-	1	1,913.9	0

Албан шаардлага	2	25,036.0	1	25,036.0	-	-	100.0
Зөвлөмж	1	3,720.6	1	3,720.6	-	-	50.0
Нийт дүн	4	30,670.5		3,720.6	1	1,913.9	50.0

Шилэн дансны албан шаардлагад Төрийн аудитын тухай хуулийн 42 дугаар зүйлийн 42.1-д заасны дагуу холбогдох албан тушаалтанд сахилгын шийтгэл ногдуулах албан шаардлага хүргүүлэв.

3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Соёлын яамны ХШҮДАГ-аас Соёл урлагийн газарт хийсэн хяналт шалгалттай холбоотой байгууллагын дотоод хяналт, худалдан авах ажиллагаатай холбоотой гол асуудлуудыг дараагийн аудитаар анхаарч үзэх нь зүйтэй гэж үзлээ.

4. Аудитын илрүүлэлт

Аудитаар нийт 1,353,083.1 мянган төгрөгийн алдаа зөрчил илэрснээс, 743,643.0 мянган төгрөгийн алдааг залруулж, 609,440.1 мянган төгрөгийн зөрчилд албан шаардлага, өмнөх оны аудитаар өгсөн төлбөрийн акт, төсвийн гүйцэтгэлийн тайлангийн талаар 2 зөвлөмж хүргүүлсэн.

Залруулагдаагүй алдаа, зөрчлийн дүн 351,257.8 мянган төгрөг нь бидний тогтоосон материаллаг байдлын түвшин 11,831.3 мянган төгрөгөөс хэтэрсэн тул Хязгаарлалттай дүгнэлт өглөө.

4.1 Залруулсан алдаа

Аудитаар нягтлан бодох бүртгэлийн бичилт, тооцоолол болон тайлагналын алдаатай дараах залруулгыг санхүүгийн тайланд тусгаж, баталгаажуулав. Үүнд:

Соёлын яамнаас санхүүжүүлэх 743,643.0 мянган төгрөгийн санхүүжилтийн авлагыг бүртгээгүй байсныг залруулав.

4.2 Албан шаардлага

1. Мөнгөн хөрөнгийн 1,153,073.5 мянган төгрөгийн 169 зарлагын гүйлгээний анхан шатны баримтын бүрдлийг түүвэрлэж шалгахад 99,591.8 мянган төгрөгийн гүйлгээ дэмжих баримтгүй, төлбөрийн и-баримтаар баталгаажаагүй, өмнөх аудитын зөвлөмжийг хэрэгжүүлээгүй нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.4. *"Аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага, нягтлан бодогч нь үйлдвэрлэл, үйлчилгээний шат дамжлага, аж ахуйн үйл ажиллагааны хүрээнд гарсан хөрөнгө, эх үүсвэрийн хөдлөл, өөрчлөлт бүрийг анхан шатны баримтад бичгээр болон цахимаар бичилт хийж баталгаажуулна."* гэсэн заалттай нийцэхгүй, нийцсэн бөгөөд зохистой байх, иж бүрэн байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Албан шаардлага хүргүүлэх;

2. "Алтанбулагийн музейн үзүүлэлэг дэглэлтийг шинэчлэн боловсруулах, 100 жил 100 үйл явдал антологт гаргах ажил огт хэрэгжээгүй байхад мэргэжлийн арга зүйн дэмжлэг авахаар 1 зөвлөх ажилтныг шинээр томилон 4 сар ажиллуулж, 3,972.9 мянган төгрөгийн цалин олгож үр дүнгүй зардал гаргасан. Мөн "Захиргааны хэлтсийн Хяналт-шинжилгээ, үнэлгээ, хууль тогтоомжийн биелэлт, дотоод хяналт хариуцсан ахлах мэргэжилтэн" албан тушаалд томилсон ажилтан нь байгууллагад дотоод хяналтын ажлыг хэрэгжүүлээгүй, үр дүнгийн ажлын тайланг ирүүлээгүй, 4 сарын хугацаанд 3,779.3 мянган төгрөгийг цалин, НДШ-д зарцуулж, ажлын үр дүнгүй байгаа нь Засгийн газрын 43 дугаар тогтоолын 1.2 *"Шинээр ажлын чиг үүрэг, албан тушаал бий болгохгүй, орон тоог нэмэгдүүлэхгүй байх, өндөр насны тэтгэвэр тогтоолгож чөлөөлөгдсөн ажилтан, албан тушаалтны орон тоог царцааж, нөхөн томилгоо хийхгүйгээр цалингийн зардлыг хэмнэх"*, Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1. *"төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах;"* гэсэн заалттай нийцэхгүй, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Албан шаардлага хүргүүлэх;

3. Үндэсний хөтөлбөрийн хэрэгжилтийг хангах ажлын хүрээнд Үндэсний номын санд 45,000.0 мянган төгрөг, Түүх, соёлын үл хөдлөх дурсгалын тооллогын ажил зохион байгуулахад 80,000.0 мянган төгрөг, Соёлын биет бус өвийн үзлэг хийх ажилд 66,000.0 мянган төгрөгийг тус тус үр ашиггүй зарцуулж, үр дүнг тайлагнаагүй, үзлэг тооллогын тайлан мэдээ байхгүй нь Төсвийн тухай хуулийн 6.4.1. *"төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах"* гэсэн заалттай нийцэхгүй, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Албан шаардлага хүргүүлэх

4. UB арт фестиваль төсөл, арга хэмжээ (Саунд ов Монголия ХХК), Нүүдлийн цирк 21 аймагт цахим тоглолт зохион байгуулах тусгай хөтөлбөр (Улаанбаатар цирк ХХК)-ийн санхүүжилтийн үлдэгдэл буцаан төвлөрүүлсэн 51,000.0 мянган төгрөгийн төлбөрийг санхүүгийн тайланд дансны авлагаар бүртгэсэн, үлдэгдлийг тооцоо нийлсэн актаар баталгаажуулаагүй нь Төсвийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.3. *“санхүү, төсвийн зохистой удирдлагыг хэрэгжүүлэх”*, 6 дугаар зүйлийн 6.4.8. *“төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх”* гэсэн заалттай нийцэхгүй, нийцсэн бөгөөд зохистой байх, ангилал, эрх ба үүрэг батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Албан шаардлага хүргүүлэх

4.3 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

1. **Төсвийн гүйцэтгэлийн тайлантай холбоотой асуудал**

- 1.1 Илрүүлэлт:

Төсвийн гүйцэтгэлийн тайланг Төсвийн тухай хуулийн 54.5-т заасны дагуу бүрэлдэхүүн хэсгээр иж бүрэн бэлтгээгүй. Зарим хөтөлбөр арга хэмжээнд зарцуулсан төсөв, хүрсэн үр дүн, биелэлтийн тайлан дүгнэлт ирүүлээгүй.

- 1.2 Өгсөн зөвлөмж:

Төсвийн тухай хуулийн 54 дүгээр зүйлийн 54.5. *“Төсвийн гүйцэтгэлийн тайлан нь дараах бүрэлдэхүүн хэсэгтэй байна...”* гэж заасны дагуу Төсвийн гүйцэтгэлийн тайланг иж бүрэн гаргаж, хөтөлбөр арга хэмжээнд зарцуулсан төсөв, хүрсэн үр дүн, биелэлт, хэрэгжүүлээгүй бол шалтгаан зэрэг нэмэлт мэдээллүүдийг тайлагнаж байх;

2. **Өмнөх оны аудитаар өгсөн төлбөрийн акттай холбоотой асуудал**

- 2.1 Илрүүлэлт:

2020 оны санхүүгийн тайлангийн аудитаар 2021 он 2 дугаар сарын 5-ны өдрийн 52/A0160058 тоот актын төлбөр 1,913.9 мянган төгрөгийг "тухайн зөрчил тавигдсан албан тушаалтан нас барсан" гэсэн шалтгаанаар төлж барагдуулаагүй нь Төсвийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.5 *“хариуцлагатай байх”* гэсэн заалттай нийцэхгүй, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

- 2.2 Өгсөн зөвлөмж:

Цаашид, алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллах;

Дээрх албан шаардлага, зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2022 оны 9 дүгээр сарын 30-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

№	Байгууллагын нэр	Аудитын код	Алдаа, зөрчлийн товч утга	Аудитын байгууллагын тогтоосон акт, албан шаардлага, өгсөн зөвлөмж, залруулгын товч утга	Нийт алдаа зөрчил		Залруулга		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
					Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Санхүүгийн тайлангийн асуудлаар														
1	Соёл урлагийн газар	АХГ-2022/192/НА-СТА-ТШЗ	99,591.8 мянган төгрөгийн гүйлгээ төлбөрийн и-баримтаар баталгаажаагүй, өмнөх аудитын зөвлөмжийг хэрэгжүүлээгүй.	Албан шаардлага хүргүүлсэн.	1	99,591.8					1	99,591.8		
2	Соёл урлагийн газар	АХГ-2022/192/НА-СТА-ТШЗ	Гэрээгээр гүйцэтгүүлсэн 51,000.0 мянган төгрөгийн санхүүжилтийн үлдэгдэл төлбөрийг авлагаар бүртгэж, үлдэгдлийг тооцоо нийлсэн актаар баталгаажуулаагүй.	Албан шаардлага хүргүүлсэн.	1	51,000.0					1	51,000.0		
3	Соёл урлагийн газар	АХГ-2022/192/НА-СТА-ТШЗ	Үндэсний хөтөлбөрийн хэрэгжилтийг хангах ажлын хүрээнд 191,000.0 мянган төгрөгийг зарцуулж, гүйцэтгэлийн ажлын тайлан, мэдээ байхгүй.	Албан шаардлага хүргүүлсэн.	1	191,000.0					1	191,000.0		
4	Соёл урлагийн газар	АХГ-2022/192/НА-СТА-ТШЗ	Төсвийн гүйцэтгэлийн тайланг Төсвийн тухай хуулийн дагуу иж бүрэн бэлтгээгүй.	Төсвийн гүйцэтгэлийн тайланг иж бүрэн гаргаж байх.	1	-							1	-
5	Соёл урлагийн газар	АХГ-2022/192/НА-СТА-ТШЗ	Алтанбулагийн музейн антологт хийх ажил хэрэгжээгүй байхад шинээр хүн томилсон, дотоод хяналтын ажил хэрэгжээгүй байхад цалин олгож, 7,752.2 мянган төгрөгийн үр ашиггүй зардал гаргасан.	Албан шаардлага хүргүүлсэн.	1	7,752.1					1	7,752.1		

Соёл урлагийн газрын 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд
хийсэн аудитын тайлан

6	Соёл урлагийн газар	АХГ-2022/192/НА-СТА-ТШЗ	743,643.0 мянган төгрөгийн татаас санхүүжилтийн авлагыг бүртгээгүй байсныг залруулав.	Санхүүгийн тайланд залруулга хийв.	1	743,643.0	1	743,643.0						
7	Соёл урлагийн газар	АХГ-2022/192/НА-СТА-ТШЗ	2020 оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн 1,913.9 мянган төгрөгийн актын төлбөрийг "тухайн зөрчил тавигдсан албан тушаалтан нас барсан" гэсэн шалтгаанаар төлж барагдуулаагүй.	Хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллах.	1	1,913.9							1	1,913.9
	ДҮН				7	1,094,900.8	1	743,643.0			4	349,343.9	2	1,913.9 -
Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн асуудал														
1	Соёл урлагийн газар	АХГ-2022/192/НА-СТА-ТШЗ	Тайлант хугацаанд 22 мэдээллийг хугацаа хоцроосон, 4 мэдээллийг байршуулаагүй, нийт 198,182.3 мянган төгрөгийн мэдээллийг дутуу байршуулж, давтан зөрчил гаргасан.	Хариуцлага тооцуулах албан шаардлага хүргүүлсэн.	1	198,182.3					1	198,182.3		
2	Соёл урлагийн газар	АХГ-2022/192/НА-СТА-ТШЗ	"Тусгаар тогтнол шүлгээр дуу бүтээх" ажлын багийг шалгаруулахдаа зөвхөн нэг компаниас ирүүлсэн материалыг хавсаргаж хууль бус сонгон шалгаруулалт хийж, 60,000.0 мянган төгрөгийг шилжүүлсэн.	Албан шаардлага хүргүүлсэн.	1	60,000.0					1	60,000.0		
3	Соёл урлагийн газар	АХГ-2022/192/НА-СТА-ТШЗ	Шууд гэрээ байгуулах аргыг хэрэглэх болсон үндэслэлийг гэрээний хувийн хамт Сангийн яаманд хүргүүлээгүй, шалгаруулалтын үр дүнг цахим төндөрийн сайтад мэдээлээгүй.	Албан шаардлага хүргүүлсэн.	1	-					1	-		
	ДҮН				3	258,182.3					3	258,182.3		
НИЙТ ДҮН					10	1,353,083.1	1	743,643.0			7	607,526.2	2	1,913.9



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2022 оны 02 дугаар сарын 25

№ 268 А/0150458

Улаанбаатар хот

АХГ 2022/192/НА-СТА-ТШЗ

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Төсвийн тухай хуулийн 8.9.1-д заасны дагуу Соёл, урлагийн газрын 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

УВ арт фестиваль төсөл, арга хэмжээ, Нүүдлийн цирк 21 аймагт цахим тоглолт зохион байгуулах тусгай хөтөлбөрийн санхүүжилтийн үлдэгдэл төлбөр 51,000,000.00 төгрөгийг санхүүжилтийн авлагаар бүртгэж, үлдэгдлийг тооцоо нийлсэн актаар баталгаажуулаагүй.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.5. "Дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах", 20.2.6. "Эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах" гэж заасныг тус тус зөрчсөн.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1 "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө."; Монгол Улсын Ерөнхий аудиторовын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох" журмын 4.2.1-д заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Төсөл, хөтөлбөр, арга хэмжээний санхүүжилтийн төлбөрүүдийг Сангийн яамтай тооцоо нийлж, актаар баталгаажуулсан тохиолдолд санхүүжилтийн авлагаар бүртгэж, биелэлтийг 2022 оны 9 дүгээр сарын 30-ны өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх;
2. Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Соёл, урлагийн газрын дарга Ц.Нацагдолгор, нягтлан бодогч Г.Одончимэг нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

АУДИТЫН ХОЁРДУГААР ГАЗРЫН
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР
АУДИТЫН МЕНЕЖЕР
ШИНЭ ИХ ТЭРБУМ АУДИТ ХХК-ИЙН
АХЛАХ АУДИТОР

Ц.НАРАНЧИМЭГ
С.НАЦАГДОРЖ
Т.МЕРУЕРТ

0010800833



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2022 оны 02 дугаар сарын 25

№ 269 АО/ОИСД/458

Улаанбаатар хот

АХГ 2022/192 ИНА-СТА-ТНБ

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Төсвийн тухай хуулийн 8.9.1-д заасны дагуу Соёл урлагийн газрын 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Алтанбулагийн музейн үзүүлэлэг дэглэлтийг шинэчлэн боловсруулах, 100 жил 100 үйл явдал антологт гаргах ажил огт хэрэгжээгүй байхад мэргэжлийн арга зүйн дэмжлэг авахаар 1 зөвлөх ажилтныг шинээр томилон 4 сар ажиллуулж, 3,972,995.00 төгрөгийн цалин олгосон байна. Мөн Захиргааны хэлтсийн Хяналт-шинжилгээ, үнэлгээ, хууль тогтоомжийн биелэлт, дотоод хяналт хариуцсан ахлах мэргэжилтэн албан тушаалд томилсон ажилтан нь байгууллагад дотоод хяналтын ажлыг хэрэгжүүлээгүй, үр дүнгийн ажлын тайланг гаргаж ирүүлээгүй бөгөөд 4 сарын хугацаанд 3,779,271.00 төгрөгийн цалин олгож, нийгмийн даатгалын шимтгэлийн үргүй зардал гаргасан.

Энэ нь Засгийн газрын 2021 оны 43 дугаар тогтоолын 1.2 "Шинээр ажлын чиг үүрэг, албан тушаал бий болгохгүй, орон тоог нэмэгдүүлэхгүй байх, өндөр насны тэтгэвэр тогтоолгож чөлөөлөгдсөн ажилтан, албан тушаалтны орон тоог царцааж, нөхөн томилгоо хийхгүйгээр цалингийн зардлыг хэмнэх", Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1. "төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах," гэж заасныг тус тус зөрчсөн байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1 "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө." Монгол Улсын Ерөнхий аудиторовын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох" журмын 4.2.1-д заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Засгийн газрын 2021 оны 43 дугаар тогтоолын хэрэгжилтийг хангаж, төсвийг үр ашигтай төлөвлөн зарцуулж, биелэлтийг 2022 оны 9 дүгээр сарын 30-ны өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх;
2. Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Соёл, урлагийн газрын дарга Ц.Нацагдолгорт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

АУДИТЫН ХОЁРДУГААР ГАЗРЫН
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР
АУДИТЫН МЕНЕЖЕР
ШИНЭ ИХ ТЭРБУМ АУДИТ ХХК-ИЙН
АХЛАХ АУДИТОР

Ц.НАРАНЧИМЭГ
С.НАЦАГДОРЖ

Т.МЕРУЕРТ

9006109
9019120396

0010800829



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2022 оны 02 дугаар сарын 25

№ 240 АО/0150458

Улаанбаатар хот

АХГ 2022/192/НА-СТА-ТМБ

Сахилгын хариуцлага тооцуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Төсвийн тухай хуулийн 8.9.1-д заасны дагуу Соёл урлагийн газрын 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийг хангуулахаар өгсөн албан шаардлагыг хэрэгжүүлээгүй, тайлант онд шилэн дансны цахим сайтад 174 мэдээлэл байршуулахаас 883,915,100.00 төгрөгийн орлого, зарлагын 12 гүйлгээг мэдээлээгүй, 52,913,900.00 төгрөгийн өр, авлага үүсгэсэн тухай шийдвэр, худалдан авах ажиллагаатай холбоотой 144,900,000.00 төгрөгийн мэдээлэл, тушаал шийдвэр, тайлан, бусад материалыг тус тус хавсаргаж мэдээлээгүй, өмнөх оны зөрчлийг давтан гаргасан.

Энэ нь Шилэн дансны тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.1-д “мэдээлэл үнэн зөв, бодитой, иж бүрэн байх”; 4.1.3-д “тогтоосон хугацаанд, тогтмол, шуурхай мэдээлдэг байх”; Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавигдах мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-д заасныг тус тус зөрчсөн байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 42 дугаар зүйлийн 42.3-т “Энэ хуулийн 42.1, 42.2-т заасан үндэслэл бүрдсэн тохиолдолд төрийн аудитын байгууллага тухайн албан хаагчид холбогдох сахилгын шийтгэл ногдуулах талаар эрх бүхий албан тушаалтанд албан шаардлага өгөх ба эрх бүхий албан тушаалтан ямар шийдвэр гаргасан талаараа албан шаардлагад заасан хугацаанд төрийн аудитын байгууллагад хариу мэдэгдэнэ” гэсэн заалтыг үндэслэн **ШААРДАХ нь:**

Зөрчил гаргасан буруутай албан тушаалтанд хуульд заасны дагуу сахилгын шийтгэл оногдуулж, биелэлтийг 2022 оны 09 дүгээр сарын 30-ны өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэхийг Соёл урлагийн газрын дарга Ц.Нацагдолгорт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

АУДИТЫН ХОЁРДУГААР ГАЗРЫН
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР
АУДИТЫН МЕНЕЖЕР
ШИНЭ ИХ ТЭРБУМ АУДИТ ХХК-ИЙН
АХЛАХ АУДИТОР

Ц.НАРАНЧИМЭГ
С.НАЦАГДОРЖ
Т.МЕРУЕРТ

Монгол Улс, Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, 1-р хороо, Бага тойруу-3, Засгийн газрын 4 дүгээр байр, Утас 51-264230

\\10.10.10.20\Bichig_Khereg\Alban Shaardlaga\2022\0225 Auditin 2 Gazar-267.Docx

0010800823



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2022 оны 02 дугаар сарын 25 № 241/А.0150458
АХГ-2022/192/НА-СТА-ТМС

Улаанбаатар хот

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Төсвийн тухай хуулийн 8.9.1-д заасны дагуу Соёл, урлагийн газрын 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Мөнгөн хөрөнгийн зарлагын 99,591,809.00 төгрөгийн гүйлгээ дэмжих баримтгүй, төлбөрийн и-баримтаар баталгаажуулж байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.4. "Аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага, нягтлан бодогч нь үйлдвэрлэл, үйлчилгээний шат дамжлага, аж ахуйн үйл ажиллагааны хүрээнд гарсан хөрөнгө эх үүсвэрийн хөдлөл, өөрчлөлт бүрийг анхан шатны баримтад бичгээр болон цахимаар бичилт хийж баталгаажуулна.", 13.5. "Анхан шатны баримтад түүнийг үйлдсэн, зөвшөөрсөн буюу шалгасан ажилтан гарын үсэг зурж, тамга, тэмдэг дарснаар уг баримт хүчин төгөлдөр болно. Цахим хэлбэрээр бүрдүүлсэн анхан шатны баримт нь цахим гарын үсгээр баталгаажсан байна.", 13.7. "Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно." гэж заасныг тус тус зөрчсөн байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1 "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө."; Монгол Улсын Ерөнхий аудиторовын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох" журмын 4.2.1-д заасныг үндэслэн **ШААРДАХ** нь:

1. Мөнгөн хөрөнгийн зарлагын баримтуудыг төлбөрийн и-баримтаар баталгаажуулж, биелэлтийг 2022 оны 9 дүгээр сарын 30-ны өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх;
2. Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Соёл урлагийн газрын дарга Ц.Нацагдолгор, нягтлан бодогч Г.Одончимэг нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

АУДИТЫН ХОЁРДУГААР ГАЗРЫН
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР
АУДИТЫН МЕНЕЖЕР
ШИНЭ ИХ ТЭРБУМ АУДИТ ХХК-ИЙН
АХЛАХ АУДИТОР

Ц.НАРАНЧИМЭГ
С.НАЦАГДОРЖ
Т.МЕРУЕРТ

0010800827



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2022 оны 02 дугаар сарын 25 № 272/А0150458

Улаанбаатар хот

АХГ-2022/192/НА-СТА-ТМД

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Төсвийн тухай хуулийн 8.9.1-д заасны дагуу Соёл, урлагийн газрын 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Үндэсний хөтөлбөрийн хэрэгжилтийг хангах ажлын хүрээнд Үндэсний номын санд 45,000,000.00 төгрөг, түүх, соёлын үл хөдлөх дурсгалын тооллогын ажил зохион байгуулахад 80,000,000.00 төгрөг, соёлын биет бус өвийн үзлэг хийх ажилд 66,000,000.00 төгрөгийг тус тус зарцуулж, үр дүнг тайлагнаагүй, үзлэг тооллогын тайлан мэдээ байхгүй.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн "5.1.3. "санхүү, төсвийн зохистой удирдлагыг хэрэгжүүлэх", 6 дугаар зүйлийн 6.4.1. "төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах;" гэж заасныг тус тус зөрчсөн.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1 "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө."; Монгол Улсын Ерөнхий аудиторовын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох" журмын 4.2.1-д заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Хөтөлбөр, арга хэмжээд зарцуулсан төсөв, хүрсэн үр дүн, гүйцэтгэлийн биелэлт, түүний үр дүнд хийсэн дүгнэлт, ажлын тайлан зэргийг тайлагнаж, биелэлтийг 2022 оны 9 дүгээр сарын 30-ны өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх;
2. Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Соёл, урлагийн газрын дарга Ц.Нацагдолгор, нягтлан бодогч Г.Одончимэг нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

АУДИТЫН ХОЁРДУГААР ГАЗРЫН
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР
АУДИТЫН МЕНЕЖЕР
ШИНЭ ИХ ТЭРБУМ АУДИТ ХХК-ИЙН
АХЛАХ АУДИТОР



Ц.НАРАНЧИМЭГ
С.НАЦАГДОРЖ
Т.МЕРУЕРТ

0010800831



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2022

оны

02

дугаар сарын

25

№

273/A0150458

Улаанбаатар хот

АХГ-2022/192/НА-СТА-ТМЗ

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Төсвийн тухай хуулийн 8.9.1-д заасны дагуу Соёл, урлагийн газрын 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Худалдан авах ажиллагаатай холбоотой дараах зөрчлүүд гарсан. Үүнд:

- "Нүүдлийн цирк 21 аймаг" тоглолтын 210,000,000.00 төгрөгийн төсөвт өртөгтэй тендер шалгаруулалтыг шууд гэрээ байгуулах нөхцөлөөр Улаанбаатар цирк ХХК-ийн ирүүлсэн 209,990,000.00 төгрөгийн саналыг шалгаруулж, шууд гэрээ байгуулах аргыг хэрэглэх болсон үндэслэлийг Сангийн яаманд хүргүүлээгүй, шалгаруулалтын үр дүнг цахим тендерийн сайтад мэдээлээгүй,
- Ардын хувьсгалын 100 жилийн ойг тохиолдуулан 100,000,000.00 төгрөгийн төсөвт өртөгтэй "Тусгаар тогтнол шүлгээр дуу бүтээх" сонгон шалгаруулалтад 3 байгууллагаас үнийн санал, материал ирүүлсэн гэж дурдсан боловч ажлын баримтад зөвхөн Медиа боловсрол суваг ХХК-ийн материалыг хавсаргаж хууль бус сонгон шалгаруулалт хийж, төлбөрийн 60% буюу 60,000,000.00 төгрөгийг шилжүүлсэн байна.

Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа ажил үйлчилгээ худалдан авах тухай" хуулийн 34 дүгээр зүйлийн 34.3 "Энэ хуулийн 34.1-д заасны дагуу гэрээ шууд байгуулсан тохиолдолд захиалагч гэрээний хувийг уг аргыг хэрэглэх болсон үндэслэлийн хамт төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад хүргүүлнэ.", 8 дугаар зүйлийн 8.2 "Энэ хуулийн 8.1.1-д заасан босго үнээс дээш төсөвт өртөгтэй бараа, ажил, үйлчилгээг худалдан авахад энэ хуульд өөрөөр заагаагүй бол нээлттэй тендер шалгаруулалтын журмыг хэрэглэнэ.", 17 дугаар зүйлийн 17.1 "Нээлттэй тендер шалгаруулалтын урилгыг энэ хуулийн 21 дүгээр зүйлд заасны дагуу зарлан мэдээлж, сонирхогч этгээдийг тендер шалгаруулалтад оролцох тэгш боломжоор хангана." гэж заасныг тус тус зөрчсөн байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1 "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө."; Монгол Улсын Ерөнхий аудиторовын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох" журмын 4.2.1-д заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн дагуу худалдан авах ажиллагааг зохион байгуулах, холбогдох хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангах, алдаа зөрчлийг арилгаж, албан шаардлагын биелэлтийг 2022 оны 9 дүгээр сарын 30-ны өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх;
2. Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Соёл, урлагийн газрын дарга Ц.Нацагдолгор, нягтлан бодогч Г.Одончимэг нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

АУДИТЫН ХОЁРДУГААР ГАЗРЫН
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР
АУДИТЫН МЕНЕЖЕР
ШИНЭ ИХ ТЭРБУМ АУДИТ ХХК-ИЙН
АХЛАХ АУДИТОР



Ц.НАРАНЧИМЭГ
С.НАЦАГДОРЖ
Т.МЕРУЕРТ